



СЭЛЭНГЭ АЙМАГ  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/176

Алтанбулаг

Шалгарсан төсөлд зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолын хавсралт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 15 тоот, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 50 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гаргасан 2021 оны 09 сарын 10-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэл, шийдвэрийн дагуу Сум хөгжүүлэх сангаас олгох 15,000,000 (Арван таван сая) төгрөгийг "Мах сүүний чиглэлийн эрчимжсэн үхрийн аж ахуй" төсөл хэрэгжүүлэгч Энхтөр овогтой Ганзоригт олгосугай.

2.Батлагдсан төслийг журамд заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлж, зээлийн гэрээ хийж гүйцэтгэхийг Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн (Б.Одмаа), Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Э.Цэнд-Аюуш) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ